

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАНХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/23/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	9
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	11
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	11
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	Error! Bookmark not defined.
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	Error! Bookmark not defined.
Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	Error! Bookmark not defined.
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	Error! Bookmark not defined.
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	17
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	18

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагараа бс. Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.09.25 № 21/1306
танай _____ -ны № _____ -т

МАНХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ЯДАМЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Манхан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хууль тогтоомжид нийцүүлсэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай, ил тод, хүртээмжтэй хүргэх санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

ᠠᠶᠢᠨᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠢ

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,078,776.34</u>	<u>38,093,876.00</u>
33	АВЛАГА	6,495,951.34	9,824,162.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	88,640.34	11,300.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	865,551.00
335	Бусад авлага	6,407,311.00	8,947,311.00
3351	Байгууллагаас авах авлага	6,407,311.00	8,947,311.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,817,625.00	21,284,514.00
354	Хангамжийн материал	22,817,625.00	21,284,514.00
35420	Аж ахуйн материал	22,817,625.00	21,284,514.00
36	НӨӨЦИЙН БАРАА	7,765,200.00	6,985,200.00
36300	Тэжээлийн нөөц	7,765,200.00	6,985,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,061,777,572.52</u>	<u>2,297,620,320.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,061,777,572.52	2,297,620,320.02
392	Биет хөрөнгө	1,968,346,397.60	2,204,412,895.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,959,527,376.99	2,281,920,305.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(606,424,616.14)	(725,993,214.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,819,940.00	211,819,940.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(162,856,666.32)	(179,603,317.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,579,970.00	254,683,593.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,100,785.67)	(111,493,770.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,818,674.00	68,061,074.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,529,217.62)	(49,861,420.54)
39209	Зам, гүүрийн байгууламж	836,286,906.00	836,286,906.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(384,452,183.64)	(449,084,200.68)

39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,000,000.00	5,000,000.00
39217	Ном	62,677,000.00	62,677,000.00
393	Биет бус хөрөнгө	93,431,174.92	93,207,424.88
39301	Програм хангамж	2,645,000.00	2,705,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,735,625.08)	(2,019,375.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,521,800.00	92,521,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,098,856,348.86</u>	<u>2,335,714,196.02</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,098,856,348.86</u>	<u>2,335,714,196.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,098,856,348.86	2,335,714,196.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	974,241,350.00	974,241,350.00
51101	Өмч: - төрийн	974,241,350.00	974,241,350.00
512	Хуримтлагдсан үр дүн	117,570,210.43	354,428,057.59
51210	Өмнөх үеийн үр дүн	117,570,210.43	117,570,210.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	236,857,847.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,007,044,788.43	1,007,044,788.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,098,856,348.86</u>	<u>2,335,714,196.02</u>

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	767,421,580.00	958,651,550.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,896,183.00	443,659,072.00
120	Нийтлэг татварын бус орлого	93,896,183.00	443,659,072.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,347,031.00	442,116,572.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,742,031.00	442,116,572.00
120009	Бусад орлого	5,549,152.00	1,542,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,525,397.00	514,992,478.10

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,090,897.00	71,420,578.10
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	71,276,578.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,891,652.00	144,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	624,434,500.00	443,571,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,514,900.00	422,491,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	33,848,900.00	21,080,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	591,911,756.25	722,398,702.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591,911,756.25	722,308,704.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,731,756.25	698,501,855.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,401,855.52	248,922,707.56
210101	Үндсэн цалин	212,401,855.52	248,922,707.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,656,010.14	33,414,666.38
210201	Тэтгэврийн даатгал	18,502,581.41	22,489,014.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,176,774.28	2,762,885.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,687,659.40	2,031,199.52
210204	Ажилгүйдлийн даатгал	415,150.89	470,889.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3,873,844.16	5,660,677.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,468,897.00	39,091,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,363,567.00	2,971,000.00
210302	Түлш, халаалт	41,105,330.00	36,120,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,834,975.00	32,597,476.00
210401	Бичиг хэрэг	3,690,850.00	3,510,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,495,325.00	25,440,576.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,683,700.00	3,321,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,327,600.00	325,000.00
2105	Нормативт зардал	458,800.00	99,000.00
210502	Хоол, хүнс	280,800.00	24,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178,000.00	75,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,018,755.60	294,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	154,100.00
210604	Урсгал засвар	2,838,050.00	140,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,212,694.00	3,803,000.00
210702	Дотоод албан томилолт	7,212,694.00	3,803,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,947,744.00	28,113,465.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,147,750.00	27,376,476.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,320.00	107,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,674.00	10,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	108,000.00	333,200.00
210807	Газрын төлбөр	138,000.00	26,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,732,024.99	312,165,740.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,302,686.00	87,117,036.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,092,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,429,338.99	217,956,204.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,000.00	23,806,849.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,000.00	15,585,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	15,505,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	80,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	8,221,649.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,221,649.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	89,998.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	89,998.00
222001	Тоног төхөөрөмж	-	89,998.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>175,509,823.75</u>	<u>236,252,847.16</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>175,493,028.39</u>	<u>236,252,847.16</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	427,111,897.00	522,229,978.10
118304	Нохойны албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,154,152.00	2,147,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,154,152.00	2,147,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
120009	Бусад орлого	5,549,152.00	1,542,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,957,745.00	520,082,478.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,090,897.00	71,420,578.10
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	71,276,578.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,891,652.00	144,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	371,866,848.00	448,661,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,017,948.00	427,581,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	33,848,900.00	21,080,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	427,111,897.00	502,887,610.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,111,897.00	502,887,610.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,157,252.00	478,215,209.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,314,100.00	248,878,100.00
210101	Үндсэн цалин	147,424,100.00	167,618,400.00
210102	Нэмэгдэл	37,393,800.00	48,236,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,496,200.00	33,023,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,539,400.00	33,381,933.60
210201	Тэтгэврийн даатгал	18,046,700.00	23,643,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,123,200.00	2,488,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,698,500.00	1,991,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,700.00	409,733.60

210205	Эрүүл мэндийн даатгал	4,246,300.00	4,849,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,125,400.00	39,985,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,363,567.00	3,211,000.00
210302	Түлш, халаалт	40,761,833.00	36,774,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,107,200.00	27,827,400.00
210401	Бичиг хэрэг	3,249,900.00	3,196,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,609,900.00	21,309,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,247,400.00	3,321,400.00
2105	Нормативт зардал	402,000.00	75,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	75,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,737,400.00	420,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	3,537,400.00	220,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,294,400.00	3,803,000.00
210702	Дотоод албан томилолт	7,294,400.00	3,803,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,011,900.00	29,868,665.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,033,900.00	29,049,876.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	107,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	425,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	26,189.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,625,452.00	93,975,311.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,625,452.00	85,523,111.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	8,452,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,954,645.00	24,672,400.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	330,000.00	15,585,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	15,505,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	330,000.00	80,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,624,645.00	9,087,200.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,624,645.00	9,087,200.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	19,342,368.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	19,342,368.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,342,368.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,342,368.00
222001	Тоног төхөөрөмж	-	19,342,368.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(19,342,368.00)

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	117,570,210	2,098,856,349
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	117,570,210	2,098,856,349
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	117,570,210	2,098,856,349
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	117,570,210	2,098,856,349
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	117,570,210	2,098,856,349
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	236,857,847	236,857,847
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241,350	1,007,044,788	354,428,058	2,335,714,196

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	449 266 900.00	441045250.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428616900.00	421702882.60

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,781,700	406,117,683
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,922,200	248,878,100
210101	Үндсэн цалин	167,618,400	167,618,400
210102	Нэмэгдэл	48,280,700	48,236,600
210105	Гэрээт ажлын хөлс	33,023,100	33,023,100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,554,200	33,381,934
210201	Тэтгэврийн даатгал	23,797,600	23,643,300
210202	Тэтгэмжийн даатгал	2,439,200	2,488,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,951,400	1,991,000
210204	Ажилгүйдлийн даатгал	487,500	409,734
210205	Эрүүл мэндийн даатгал	4,878,500	4,849,200
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,059,700	39,985,300
210301	Гэрэл, цахилгаан	3,574,300	3,211,000
210302	Түлш, халаалт	37,485,400	36,774,300
2104	Хангамж, бараа материалын зардал	27,898,800	27,827,400
210401	Бичиг хэрэг	3,196,200	3,196,200
210402	Тээвэр, шатахуун	21,309,800	21,309,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,392,800	3,321,400
2105	Нормативт зардал	357,000	75,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	357,000	75,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	486,400	420,500
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000	200,000
210604	Урсгал засвар	286,400	220,500
2107	Томилолт, зочны зардал	5,670,000	3,803,000
210702	Дотоод албан томилолт	5,670,000	3,803,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,417,000	26,444,689
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,265,000	25,625,900
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000	260,000

210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000	107,600
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425,000	425,000
210807	Газрын төлбөр	147,000	26,189
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,416,400	25,301,760
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,881,800	16,849,560
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,534,600	8,452,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,835,200	15,585,200
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,835,200	15,585,200
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,505,200	15,505,200
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	330,000	80,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,650,000	19,342,368
2200	Дотоод эх үүсвэрээр	20,650,000	19,342,368
222001	Тоног төхөөрөмж	20,650,000	19,342,368
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	449,266,900	441,045,251
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	427,581,900	419,360,251
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,080,000	21,080,000
132001	Орон нутгийн төсвөөс	21,080,000	21,080,000
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000	605,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	605,000

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,097,527.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,097,527.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,097,527.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,423,976.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,423,976.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,673,551.10

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,673,551.10
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,097,527.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,097,527.10
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,411,027.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,686,500.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Манхан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Г.Ядамжавд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын анхан шатны баримтын бүрдэл, үр дүнгийн урамшуулал бодох олгох талаар менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 02-наас 2021 оны 03 дугаар сарын 05-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор **гэрээт аудитор Н.Батжаргал, Д.Цогзол** хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Манхан сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах” гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Манхан сумын Засаг даргын Тамгын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 591747.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5917.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 722398.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7224.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Манхан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 236857.8 мянган төгрөгөөр буюу 11,1 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	6495,9	14037.3	7541.4
БАРАА МАТЕРИАЛ	30582,8	28269.7	2313.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3361876.6	3815675.6	453798.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2098856,3	234084.1	241947.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0.00	(0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2098856,3	2340804.1	24194.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2098856,3	2340804.1	24194.7

Оны эхэнд 6495,9 мянган төгрөгийн авлага байснаас, тайлант онд 7630,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нийт 8418.2 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Тайлант онд нийт 14914.1 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Үүнээс өмнөх оны нэмэлт санхүүжилтын авлага 5090.0 мянган төгрөг, тайлант онд нэмэлт дансны татан төвлөрүүлсний авлага 865,5 мянган төгрөг, 7630.0 мянган төгрөг үндсэн хөрөнгө бэлтгэх авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30582,8 мянган төгрөг болж 28245,7 төгрөгөөр буурсан нь тайланд онд 2337,1 мянган төгрөгийн аж ахуйн материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2061777,6 мянган төгрөг, оны эцэст 2299378,6 мянган төгрөг болж 237601,0 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 10679,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1192,3 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан. ОНХСангаар 332392,9 мянган төгрөгийн барилга байгууламж, 3000,0 мянган төгрөгийн машин засвар, 115423,6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1240,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 60,0 мянган төгрөгийн программ хангамж тус тус хандиваар 442116,5 мянган төгрөгийн хөрөнгийг тогтоол шийдвэрийн дагуу бүртгэлд тусгасан байна. Тайлант онд хөрөнгө акталж устгаагүй байна.

Өр төлбөр оны эхэнд болон тайлант онд үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2335714.1 мянган төгрөг болж тайлант онд 241947.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Манхан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 964346.5 мянган төгрөгөөр буюу 12,3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 964346.5 мянган төгрөгийн орлогоос 448661.9 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 2629.8 мянган төгрөгийн бусад орлого, өөрийн орлого 605.0 мянган төгрөг, 66909,0 мянган төгрөг Хөшөөт хөгжлийн сангаас тохижилтод, 442116,5 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 130397,0 мянган төгрөг буюу 22 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 43279,5 мянган төгрөг буюу 18 хувиар өссөн. Тогтмол зардал 4377,1 мянган төгрөг буюу 22,3 хувиар Эд хогшил, урсгал засвар 2724,6 мянган төгрөг буюу 9,7 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардал 8834,3 мянган төгрөг буюу 76,0 хувь бараа үйлчилгээний бусад зардал 82433,7 мянган төгрөг буюу 35 хувь хангамж бараа материалын зардал 762,5 мянган төгрөг буюу 0,2 хувь нормативд зардал нь 1637,5 мянган төгрөг буюу 100 хувь, томилолт 3409,6 төгрөг 52,7 хувиар буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 449266,9 мянган төгрөгөөр нийт зардлыг 449266,9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлан онд орон нутгийн 427581,9 мянган төгрөг, Орон нутгийн хөгжийн сангаас 21080,0 мянган төгрөг, Өөрийн орлого 605,0 мянган төгрөг нийт 449266,9 мянган төгрөгийн санхүүжилт авч 8221,6 мянган төгрөгийг төвлөрүүлж нийт 441045,3 мянган төгрөг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 449266,9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 8221,6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар аймгийн засаг даргын тамгын газраас 300,0 мянган төгрөгийг тэргүүний багт, Статистикаас 3423,9 мянган төгрөг хүн амын орон сууцны тооллогын цалин, шатахуун, Сонгуулийн хорооноос 144,0 мянган төгрөгийн хоолны мөнгө, өвс тэжээлийн 780,0 мянган төгрөг, Цахим төндөрийн хураамж 762,5 мянган төгрөг, Статистикаас 643,3 мянган төгрөгийг хагас жилийн мал тооллогын цалин, шатахуун, Хөшөөт хөгжлийн сангаас

66909,2 мянган төгрөгийг (сумын гэрэлтүүлэгт-18423,0 мянган төгрөг, цэцэрлэгт хүрээлэнд-25852,6 мянган төгрөг, Соёлын төвийн гадна тохижилтод-22633,4 мянган төгрөг) тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 142 мэдээллээс хугацаандаа оруулсан 9 мэдээллийн хугацаа хоцорсон боловч бүх мэдээллийг бүрэн бөглөж илгээсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Улсын тусгай хамгаалалттай байгалийн үзэсгэлэнт газарт нэвтрэх зөвшөөрөл олгосны төлбөр хураамжийг хуулийн дагуу зохион байгуулж орлого бүрдүүлэхэд санаачлагатай ажиллах гэсэн зөвлөмж Ковид-19 холбоотой хэрэгжээгүй, мөн ЗДТГ-ын жолоочийн замын хуудас бичүүлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналыг хэрэгжүүлж ажиллах гэсэн зөвлөмжийн 62 хувьтай биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	0	0	0	0	2	0
Нийт дүн	2	0	0	0	0	2	0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16311.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7799.7 мянган төгрөгийн зөвлөмж, 8411,6 мянган төгрөгийн алдааг залруулж зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар хэмнэгдсэн зардлаас төвлөрүүлсэн 8221,6 мянган төгрөгийг авлагат уясан, Үндсэн хөрөнгийн бүртгэлд бараа материал бүртгэсэн 189,9 мянган төгрөгийн алдааг тус тус залруулсан.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 7899,7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ-ын харилцахаар гарсан гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрлээ. Тухайлбал: Тушаалын төлөвлөлт буруу, Томилолт, олгосон урьдчилгаа, шатахууны тооцоон дээр жолоочийн тооцооны хүснэгт дутуу бодсон гэх мэт. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2 Өгсөн зөвлөмж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7-дахь заалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2 Цалин хөлс нэмэгдэл урамшуулалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Урамшуулалт цалинг ээлжийн амралттай хугацаанд олгосон нь Монгол улсын ЗГ-ын 2019 оны 5-р тогтоолын холбогдох заалтыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөж урамшуулалт цалин үнэн зөв бодох олгох

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Манхан сумын Засаг даргын Тамгын газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/23/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Манхан сумын Засаг даргын Тамгын газар	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Урамшуулалт цалинг ажилласан хугацаанд ноогдуулж олгох, Тушаалын төлөвлөлтөд анхаарах	977,0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Г.Ядамжав Б.Гансүх
2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, засвартай Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлэлт дутуу, жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагдсан	6922,5	Зөвлөмж өгөх		
3	Үндсэн хөрөнгө, төлөвлөрүүлэг шилжүүлгийг залруулсан.	8411.6	Залруулга		
Дүн		16311.1			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР